



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 04-р сарын 09

Дугаар 01

Улаанбаатар хот

ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧ СОНГОХ ТУХАЙ

Хувьцаа Эзэмшигчдийн Хурлаас тогтоох нь:

2016 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн Хувьцаа Эзэмшигчдийн Хурлыг /цаашид

ХЭХ гэх/ удирдах тэргүүлэгчдийг дараахь бүрэлдэхүүнтэй сонгож баталсугай:

1. Л.Шагдаррагчаа - хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн дарга
2. С.Сүхбаатар - хувьцаа эзэмшигч
3. Г.Буд - хувьцаа эзэмшигч

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 04-р сарын 09

Дугаар 02

Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ, ХУРЛЫН ДЭГ БАТЛАХ ТУХАЙ

Хурлын дэгийг доорх байдлаар баталсугай:

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн /ТУЗ/ тайлан – 10 минут
ТУЗ-ын дарга Л.Шагдаррагчаа
2. Компанийн 2015 оны санхүүгийн үйл ажиллагааны тайлан – 10-15 минут
нягтлан бодогч А.Мөнхцоож
3. Гэрээт аудитын мэдээлэл/дүгнэлт
4. Компанийн 2016 оны үйл ажиллагааны чиглэл, /өнгөрсөн оны/ үр
дүнгийн болон ногдол ашиг хуваарилах тухай – 10 минут
Гүйцэтгэх захирал Ш.Эрдэнэбат
5. Асуулт, хариулт хүн тус бүр 3 минут
6. Үг хэлэх, санал шүүмжлэл - хүн тус бүр 5 минут
7. Хурлаас гарах шийдвэрийн төсөл хэлэлцэхэд цаг тогтоохгүй

ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИД



Г.БУД
Л.ШАГДАРРАГЧАА
С.СҮХБААТАР



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 04-р сарын 09

Дугаар 03

Улаанбаатар хот

КОМПАНИЙН САНХҮҮ, БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН ТУХАЙ

“Барилга” Корпораци ХК-ийн ТУЗ-ийн болон 2015 оны санхүүгийн нэгдсэн тайлан, 2016 оны үйл ажиллагааны чиглэл, гэрээт аудитын дүгнэлт зэрэг мэдээллүүдийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцээд ТОГТООХ НЬ:

1. ТУЗ, Гүйцэтгэх удирдлагаас 2015 онд хийсэн ажлыг хэвийн гэж үзсүгэй.
2. Байгууллагын 2015 оны орлогыг 4.3 тэрбум, зарлагыг 3.6 тэрбум төгрөгөөр, цэвэр ашгийг 0,7 тэрбум төгрөгөөр баталсугай.
3. Байгууллагын 2016 оны үйл ажиллагааны үндсэн чиглэл, орлого, зарлагын нэр төрлийг хавсралтаар баталсугай. /Хавсралт/
4. Байгууллагын хөгжлийн дунд болон урт хугацааны бизнесийн нарийвчилсан төлөвлөгөө болон эдийн засгийн хямралын үеийн эрсдлийн төлөвлөгөөг батлан мөрдүүлж, удирдах чиглэл гаргаж ажиллахыг ТУЗ-д үүрэг болгосугай.
5. 2016 онд “Оюу Толгой” төслийн хүрээнд хэрэгжүүлэх гэрээт ажлын хэмжээ буурч байгаа хэдий ч өмнөх оныхтой ижил хэмжээнд хүргэх санаачлага гарган ажиллах, Улаанбаатар хот болон бусад бүсэд дотоод, гадаадын хөрөнгө оруулалтаар болон концессийн гэрээгээр барилга байгууламж барих, авто цогцолборын барилгыг бариулах, катерингийн болон зөвлөх үйлчилгээ үзүүлэх талаар санаачлагатай ажиллах замаар орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллахыг ТУЗ, Гүйцэтгэх удирдлагад даалгасугай.

ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИД



Г.БУД

Л.ШАГДАРРАГЧАА

С.СҮХБААТАР



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 04-р сарын 09

Дугаар 04

Улаанбаатар хот

ЦЭВЭР АШГИЙН ХУВААРИЛАЛТЫН ТУХАЙ

Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2016 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. 2015 оны үйл ажиллагааны цэвэр ашгаас хуваарилагдах нэгж хувьцаанд ногдох ашгийг 737 төгрөгөөр тооцож хуваарилахаар тогтоосугай. /1-р хавсралтаар/
2. ТУЗ болон төв оффисын ажилтнуудад олгох үр дүнгийн урамшуулалд 10 сая төгрөгийг хуваарилсугай. /2,3-р хавсралтуудаар/
3. Компанийн бизнесийн үйл ажиллагааг өргөтгөх, үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбогдсон арга хэмжээний зардалд зориулан ТУЗ-ийн мэдэлд 10 сая төгрөг, Гүйцэтгэх захирлын мэдлийн санд 160 хүртэл сая төгрөгийг зарцуулах эрх олгосугай.
4. Урамшууллыг компани шууд хуваарилан олгохоор тогтоосугай.

ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИД



Г.БУД

Л.ШАГДАРРАГЧАА

С.СҮХБААТАР



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 04-р сарын 09

Дугаар 05

Улаанбаатар хот

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ

“Барилга” Корпораци ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2015 оны цэвэр ашиг болон өмнөх жилүүдээс хуримтлагдсан хөрөнгөөс 2016-2017 онд компанийн өөрийн хөрөнгө оруулалтад зарцуулах хөрөнгийг баталсугай. Үүнд:
 - а. Барилгачдын талбайн ус тусгаарлалт, засварт – гүйцэтгэлээр.
 - б. Үйлчилгээний төвийн барилгыг буулгаж бизнес хөгжлийн төвийг барих хөрөнгө оруулалтад - 8 тэрбум төгрөг.
 - в. Авто худалдааны төвийн хөрөнгө оруулалтад – 2 тэрбум төгрөг.
 - г. Төв оффисын засвар, тавилга, эд хогшилд – 30 сая төгрөг.Бүгд 10.09 тэрбум төгрөг.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-д даалгасугай.

ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИД



Г.БУД

Л.ШАГДАРРАГЧАА

С.СҮХБААТАР



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 04-р сарын 09

Дугаар 06

Улаанбаатар хот

УДИРДЛАГЫН ЗАРДАЛ БАТЛАХ ТУХАЙ

“Барилга” Корпораци ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас
ТОГТООХ НЬ:

1. ТУЗ-ийн гишүүдийн цалинг нэг удаагийн хуралд
 - ТУЗ-ийн даргад 120 000 төгрөг
 - Гишүүдэд 100 000 төгрөг
 - Хурлын зардалд гүйцэтгэлээр олгохоор тогтоосугай.
2. Удирдлагын зардлын жилийн дүнг 10 сая төгрөгөнд багтаан зарцуулж байхыг ТУЗ-д зөвшөөрсүгэй.
3. Гэрээт аудитын нэг удаагийн хөлсийг 2 сая төгрөгөөр, бүгд 8 сая төгрөг байхаар баталсугай.

ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИД



Г.БУД
Л.ШАГДАРРАГЧАА
С.СҮХБААТАР



ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2016 оны 04-р сарын 09

Дугаар 01

Улаанбаатар хот

ТООЛЛОГЫН ДҮНГИЙН ТУХАЙ

“Барилга” Корпораци ХК-ийн ХЭХ-с гарах шийдвэрийг батлах саналын хуудсыг тарааж санал хураалтын дүнг нэгтгэв.

Хуралд 40177 ширхэг энгийн саналын эрхтэй хувьцаа эзэмшигч 12 гишүүн оролцсоноос 40177 хувьцаа бүхий 12 гишүүнд 12 ширхэг саналын хуудас тарааж санал хураав. Саналыг энгийн аргаар явуулж дүнг гаргав.

Шийдвэрийг батлах санал хураалтанд 12 хуудас тарааснаас хүчингүй хуудас 0, хүчинтэй хуудас 12.

	Шийдвэрийн агуулга/нэр	Зөвшөөрсөн	Татгалзсан
1	ТУЗ-ийн тайлан	12	
2	Санхүү, бизнесийн үйл ажиллагааны 2015 оны тайлан Тогтоол №03	12	
3	2015 оны ашиг хуваарилах тухай Тогтоол №04	12	
4	Хөрөнгө оруулалтын хэмжээг тогтоох тухай Тогтоол №05	12	
5	Удирдлагын зардал батлах тухай Тогтоол №06	12	

Тооллогын дүнг үндэслэн санал хураалтанд оруулсан тогтоолуудыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлуулах саналтай байна.

КОМИССЫН ДАРГА:
ГИШҮҮД:



З.КУРАЛАЙ
А.МӨНХЦООЖ
Э.БАТСҮХ